

2013 оны 5 сараас шинэчлэгдэх гэж буй гадаад иргэдийн оршин суух тухай хуулийн хатуурхал

БАЙНГЫН ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛТЭЙ ИРГЭДЭД ХАМААРАХ ӨӨРЧЛӨЛТ

БНЧУ-д ойролцоогоор 220 000 иргэн ийм зөвшөөрөлтэй байдгаас ихэнх нь Украин, Виетнам, Орос гэх мэт гуравдагч орны иргэд. Байнгын оршин суух зөвшөөрөл нь ЧУ-д найдвартай оршин суух нэг төрөл юм. Эзэмшигч нь хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй оролцох, хувийн бизнес эрхлэх цаашлаад бүх төрлийн нийгмийн халамж, мөнгөн тэтгэлгэт хамрагдах боломжийг (мөн барилга, орон сууцны хуримтлал) олгодог. Бас Шенгений орнууд руу аялах эрх, ЕХ-ны бусад орнууд руу шилжин нүүх боломжийг олгодог.

Гадаадны иргэн амжиргааны доод түвшнээс дээгүүр орлоготой бол гэр бүлээ авчрах боломж бий. Байнгын оршин суух зөвшөөрөл нь зөвхөн маш ноцтой зөрчил эсвэл ЕХ-ны орнуудаас өөр улсад нэг жилээс илүү хугацаагаар оршин суусан тохиолдолд хүчингүй болдог.

Гадаад иргэдийн оршин суух тухай шинэ хууль - байнгын оршин суух зөвшөөрөлтэй гадны иргэдийн /аль хэдийн олгогдсон иргэдэд ч хамаатай/ эзлэх **байр суурийг бууруулна**. Үүнд:

- Гадны иргэн ямар нэгэн өр төлбөр, торгуультай байвал албан хаагч байнгын оршин суух зөвшөөрлийг цуцлах эрхтэй /ЕХ-ны дүрэм журамтай харш/. Дотоод явдлын яам санхүүгийн байгууллага болон БНЧУ-ын нийгэм хамгааллын газрын мэдээллийн албанд онлайнгаар – шууд нэвтрэх эрхтэй байна.
- БНЧУ-д гэр бүлээ авчран хамт амьдрах боломж зөвхөн чинээлэг гадаадын иргэдэд боломжтой болохнээ. Гэр бүлийн нэг гишүүнд 15.400 К\$, гэр бүлийн хоёр гишүүнд 22.000 К\$, гэр бүлийн гурав ба түүнээс дээш гишүүнд 28.600 К\$-ы цэвэр орлогын /ямар ч нийгмийн халамжийн мөнгөн олговоргүй/ баталгаа үзүүлэх шаардлагатай. Тэгэхээр ихэнх гадаад иргэдийн хувьд гэр бүлийн амьдралыг иргэншил авсны дараа нээгдэнэ.
- Шинэчлэгдэх гэж буй хуулийн дагуу гадаад иргэн бүрт /15 наснаас дээш насны/ оршин суух зөвшөөрөл олгох нь тагнуулын албанаас шууд хамаарна. Тухайн гадаадын иргэн улс, ард түмний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй талаар нууц мэдээлэл олсон тухай тагнуулын албаны мэдэгдлийг үндэслэн уг гадаадын иргэн эсвэл түүний гэр бүлийн гишүүнд шалтгаан дурдалгүйгээр зөвшөөрлийг олгохоос татгалзана. Ийм тохиолдолд гадаадын иргэн тагнуулын албанаас ирүүлсэн мэдээлэлтэй танилцах, шийдвэрийг эсэргүүцэж шүүхэд хандах боломжгүй.

Чех хүн болж төрөөгүйн төлөө Төр таны амьдралд дарамт үүсгэх эрхтэй гэжүү? Эдгээр өөрчлөлтүүд танд таалагдахгүй бол бидэнтэй нэгдээрэй! jednej.cz

Холбоо барих: office@konsorcium-nno.cz

Дэлгэрнгүйг www.migraceonline.cz/cz/temata/novy-cizinecky-zakon